



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 4 дүгээр сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 31%-иар буюу 1,318 сая ам.доллараар буурч 2,960 сая ам.доллар байв. Үүнд экспорт 45%-иар буюу 1,138 сая ам.доллараар, импорт 10%-иар буюу 180 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 959 сая ам.доллараар буурч 213 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 4 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2019/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,536	12,887	13,747	2,351	22%	860	7%	3,707	4,278	2,960	571	15%	(1,318)	-31%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	2,125	2,512	1,374	387	18%	(1,138)	-45%
Импорт	4,335	5,875	6,127	1,540	36%	252	4%	1,582	1,766	1,586	184	12%	(180)	-10%
Тэнцэл	1,865	1,137	1,492	(728)		356	31%	543	746	(213)	202	37%	(959)	-129%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 918 сая ам.доллараар буурч 117 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 58% буюу 1,727 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 17% буюу 494 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 3%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 38%-иар буурлаа.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 20%-иар буурсан бол өмнөх сараас 3%-иар өсч 1.749-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс муудахад зэсийн болон чулуун нүүрсний үнийн индекс буурснаар тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас сайжрахад чулуун нүүрсний экспортын үнэ өссөнөөс голлон шалтгаалжээ.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2020 оны эхний 4 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 45%-иар буюу 1,138 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 40 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 2.4 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
1. Уул уурхай		1,944	91%	2,301	92%		1,286	94%		357	18%	17%	(1,016)	-44%	-40%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	459	628	30%	489	701	28%	429	486	35%	74	12%	3%	(215)	-31%	-9%
1.2. Чулуун нүүрс	10,142	790	37%	11,385	961	38%	4,119	334	24%	171	22%	8%	(627)	-65%	-25%
1.3. Боловсруулаагүй нефть	2,210	139	7%	2,106	118	5%	488	21	2%	(20)	-15%	-1%	(98)	-82%	-4%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	2,036	93	4%	2,842	159	6%	2,736	189	14%	67	72%	3%	30	19%	1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	7%	4,665	196	8%	1,556	80	6%	51	36%	2%	(16)	-59%	-5%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	42	75	4%	54	79	3%	50	63	5%	4	5%	0%	(16)	-20%	-1%
1.7. Жош, лейцит, нефелинт	114	36	2%	152	55	2%	197	50	4%	19	51%	1%	(5)	-8%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	14	1%	2	16	1%	2	15	1%	2	13%	0%	(1)	-9%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	1	0%	0	0	0%	(0)	-16%	0%	(1)	-97%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	-	0%	40	23	2%	(0)	0%	0%	23	0%	1%
1.11. Бусад	187	23	1%	75	15	1%	28	25	2%	(9)	-37%	0%	10	71%	0%
2. Мал аж, ахуй	161	97	5%	147	122	5%	115	34	2%	25	26%	1%	(89)	-72%	-4%
2.1. Амьд мал, малын мах	7	16	1%	9	17	1%	1	2	0%	1	9%	0%	(15)	-89%	-1%
2.2. Арьс, шир	147	8	0%	129	6	0%	110	5	0%	(2)	-24%	0%	(1)	-19%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	3	0%	0	3	0%	0	4	0%	0	45%	0%	0	15%	0%
2.4. Ноолуур	4	66	3%	3	87	3%	2	20	1%	21	32%	1%	(67)	-77%	-3%
2.5. Ноос, бусад үс, хялгас	2	4	0%	4	8	0%	2	3	0%	5	124%	0%	(5)	-65%	0%
2.6. Бусад	0	1	0%	1	1	0%	0	0	0%	0	2%	0%	(0)	-56%	0%
3. Газар тариалан	2	1	0%	15	3	0%	13	4	0%	2	256%	0%	1	23%	0%
4. Аж үйлдвэрлэл	81	83	4%	152	85	3%	69	50	4%	1	2%	0%	(35)	-41%	-1%
4.1. Хүнс	8	25	1%	10	24	1%	2	6	0%	(1)	-3%	0%	(8)	-75%	-1%
4.2. Ноолууран эдлэл	0	5	0%	0	9	0%	0	4	0%	4	74%	0%	(5)	-57%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	4	0%	1	3	0%	1	3	0%	(0)	-9%	0%	0	2%	0%
4.4. Уул уурхай	13	36	2%	45	35	1%	7	24	2%	(1)	-3%	0%	(11)	-31%	0%
4.5. Чихлэг, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	9%	0%	(0)	1%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	11	1%	0	10	0%	1	10	1%	(1)	-8%	0%	0	-7%	0%
4.7. Бусад	58	2	0%	96	2	0%	58	2	0%	0	25%	0%	(1)	-35%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-7%	0%	0	23%	0%
Нийт дүн		2,125		2,512			1,374			387	18%		(1,138)	-45%	

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 4 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	(876)		(140)		(1,016)	-44%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(68)	31%	(148)	69%	(215)	-31%
1.2. Чулуун нүүрс	(589)	94%	(38)	6%	(627)	-65%
1.3. Боловсруулаагүй нефть	(69)	70%	(29)	30%	(98)	-82%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(7)	-25%	37	125%	30	19%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(130)	113%	14	-13%	(116)	-59%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(5)	30%	(11)	70%	(16)	-20%
1.7. Жош, лейцит, нефелинт	12	-249%	(16)	349%	(5)	-8%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	-91%	(3)	191%	(1)	-9%
1.11. Бусад	(43)	-414%	53	514%	10	71%
2. Мал аж, ахуй	(48)		(40)		(89)	-72%
2.1. Амьд мал, малын мах	(30)	194%	14	-94%	(15)	-89%
2.2. Арьс, шир	(1)	73%	(0)	27%	(1)	-19%
2.4. Ноолуур	(14)	21%	(53)	79%	(67)	-77%
3. Газар тариалан	(1)	-65%	1	165%	1	23%
4. Аж үйлдвэрлэл	(153)	439%	119	-339%	(35)	-41%
5. Бусад	(0)	-116%	0	16%	0	23%
Нийт дүн	(1,078)		(61)		(1,138)	-45%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2020 оны эхний 4 сард уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 876 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 140 сая ам.доллараар буурлаа. Үүнээс чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 657 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 185 сая ам.доллараар тус тус буурав. Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалж 48 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 40 сая ам.доллараар буурсан.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 4 дүгээр сард 1,686 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 31%-иар, өмнөх сараас 6%-иар өслөө. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,058; 85 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 21%-иар, төмрийн хүдэр 10%-иар буурсан, зэсийн үнэ өмнөх сараас 2%-иар, төмрийн хүдэр 5%-иар буурлаа. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 4 дүгээр сард 82 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 6%-иар буурсан бол өмнөх сараас 19%-иар өслөө.

Импорт 2020 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10%-иар буюу 180 сая ам.доллараар буурав. Импортын 10 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг, нефтийн болон хэрэглээний бүтээгдэхүүний бууралт тус бүр 3 нэгж хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хэм (мян нэгж)	ДҮН	%	Тоо/хэм (мян нэгж)	ДҮН	%	Тоо/хэм (мян нэгж)	ДҮН	%	ДҮН	Өсөлт	% ²	ДҮН	Өсөлт	% ²	
Хэрэглээний бүтээгдэхүүн		445	28%		498	28%		450	28%		54	12%	3%	(49)	-10%	-3%
Түргэн эдлэгтэй	283	243	15%	267	249	14%	298	253	16%	6	2%	0%	4	2%	0%	
Хүнс	132	169	11%	124	176	10%	132	173	11%	7	4%	0%	(3)	-2%	0%	
Эм, тариа	1	32	2%	1	30	2%	1	35	2%	(2)	-7%	0%	5	18%	0%	
Бусад түргэн эдлэгтэй бараа	150	42	3%	142	43	2%	165	44	3%	1	2%	0%	2	4%	0%	
Удаан эдлэгтэй	54	202	13%	120	249	14%	80	196	12%	48	24%	3%	(53)	-21%	-3%	
Гутал, хувцас, цүнх	16	22	1%	22	20	1%	36	22	1%	(2)	-8%	0%	2	11%	0%	
Гэр охуйн цах.хэрэгсэл ба тавилга	17	33	2%	76	32	2%	20	30	2%	(1)	-4%	0%	(2)	-5%	0%	
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	124	8%	1	171	10%	0	119	7%	46	37%	3%	(52)	-30%	-3%	
Бусад удаан эдлэгтэй бараа	21	22	1%	21	27	2%	24	25	2%	5	22%	0%	(2)	-6%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	525	601	38%	412	717	41%	447	638	40%	116	19%	7%	(80)	-11%	-5%	
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	7	394	25%	9	501	28%	10	424	27%	107	27%	7%	(77)	-15%	-4%	
Сүүдлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	115	7%	1	169	10%	3	134	8%	53	46%	3%	(34)	-20%	-2%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	6	278	18%	8	333	19%	7	290	18%	54	19%	3%	(43)	-13%	-2%	
Барилгын материал	156	140	9%	224	163	9%	244	159	10%	23	17%	1%	(4)	-3%	0%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	12	68	4%	7	53	3%	10	55	3%	(14)	-21%	-1%	2	3%	0%	
Аж үйлдвэрлэлийн орц	447	236	15%	563	201	11%	489	211	13%	(35)	-15%	-2%	10	5%	1%	
Хүнсний орц	187	52	3%	12	6	0%	91	23	1%	(46)	-88%	-3%	16	262%	1%	
Химийн бүтээгдэхүүн	59	34	2%	66	35	2%	63	35	2%	1	3%	0%	(0)	-1%	0%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	18	8	0%	25	10	1%	23	8	1%	2	24%	0%	(1)	-13%	0%	
Цахилгаан эрчим хүч	1	47	3%	1	46	3%	1	48	3%	(1)	-2%	0%	2	4%	0%	
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	0%	0%	(0)	-50%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	261	95	6%	308	103	6%	269	97	6%	9	9%	1%	(7)	-6%	0%	
Нефтийн бүтээгдэхүүн	447	297	19%	563	347	20%	489	286	18%	50	17%	3%	(61)	-18%	-3%	
Дизель түлш	256	165	10%	334	207	12%	259	149	9%	43	26%	3%	(59)	-28%	-3%	
АИ-92, АИ-95	99	67	4%	161	91	5%	135	76	5%	24	35%	1%	(15)	-16%	-1%	
А-80 болон бусад	91	65	4%	67	49	3%	95	61	4%	(16)	-24%	-1%	12	25%	1%	
Бусад	9	3	0%	2	2	0%	80	2	0%	(1)	-36%	0%	(0)	-11%	0%	
Нийт дүн		1,582		1,766			1,586			184	12%		(180)	-10%		

²% - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 4 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	(12)	%	(37)	%	(49)	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(12)	25%	(37)	75%	(49)	-10%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	70	-88%	(150)	188%	(80)	-11%
Аж үйлдвэрлэлийн орц	6		4		10	5%
Нефтийн бүтээгдэхүүн	(40)	66%	(21)	34%	(61)	-18%
Дизель түлш	(43)	74%	(15)	26%	(59)	-28%
АИ-92, АИ-95	(15)	102%	0	-2%	(15)	-16%
А-80 болон бусад	18	145%	(6)	-45%	12	25%
Бусад	2		(2)		(0)	-11%
Нийт дүн	25	-14%	(205)	114%	(180)	-10%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2020 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 80 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 61 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 49 сая ам.доллараар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 10 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 180 сая ам.доллараар буурлаа.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 36 хувиар, өмнөх сараас 31 хувиар тус тус буурч тонн тутамд 418 ам.долларт хүрэв.